



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/205

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын Спорт цогцолборын барилгын нэмэлт ажлын санхүүжилт /Улаанбаатар/ хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:
Л.Ганбат

Худалдан авах ажиллагааны тасгийн дарга

Нарийн бичгийн дарга:
Г.Хишигдэлгэр

Худалдан авах ажиллагааны тасгийн
мэргэжилтэн

Гишүүд:

Г.Наранчимэг

Нисэх буудлуудын үйлчилгээний газрын
мэргэжилтэн

Г.Цолмон

Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

М.Оргил

“Сэтгэл зүй, судалгаа мэдээллийн төв” Төрийн
бус байгууллагын судлаач

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Л.Ганбат)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Хишигдэлгэр)-д даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 1172